



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/169

Номгон

“Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын дүрэм батлах тухай” 85 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын бүтэц, орон тооны хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлж, чиг үүргийн давхардлыг арилгаж батлагдсан орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулахыг “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын захирал (Т.Отгонбаатар)-д үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Өнөржаргал), Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т даалгасугай.

ДАРГА




Д.МӨНХСАЙХАН

1210431



БАЯНХОНГОР-ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН БҮТЭЦ



Нийт ажилтан албан хаагчдын тоо-80